



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2018.02.23, № 3/363.
танай _____-ны № _____-т
Аудитын гэрчилгээ

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
Л.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинжлэх ухааны академийн хими, химийн технологийн хүрээлэнгийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Шинжлэх ухааны академийн хими, химийн технологийн хүрээлэнгийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шинжлэх ухааны академийн хими, химийн технологийн хүрээлэнгийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.М.М.М.
УХА0122

Ц.НАРАНЧИМЭГ



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ШУА-ИЙН ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахи хаягаар харилцана уу:

АУДИТЫН ТАЙЛАН

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46 Бага тойруу 6
Web: www.mnao.gov.mn

Санхүүгийн аудитын газрын дарга
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитор: Н.Нямдаваа
Утас: 260512
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
“Бэст фортуна Аудит” ХХК
Утас: 324338
И-мэйл: fortune_audit@yahoo.com

Захирал: Ж.Оюунцэцэг
Утас: 89116465, 98056465
И-мэйл: Oyuntsetseg_cpa@yahoo.com

Аудитын багийн ахлагч:
Аудитор: Н.Одончимэг
Утас: 99066585
И-мэйл: odnoo@yahoo.com

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

**Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн
тайлан**

Агуулга

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	1
Байгууллагын хууль эрх зүйн орчин	1
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	2
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд	
түүний үр дүн	3
Материаллаг байдал	4
Дотоод хяналт	4
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	4
Шилэн дансны мэдээлэл	5
Олж тогтоосон гол эрсдлүүд	5
Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар	5
Аудитаар илэрсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар	5-7
Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар	7
Анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	7
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	7
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	7
Дүгнэлт	7

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, 18.5 дахь заалтуудыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайланд “Бэст фортуна аудит” ХХК гэрээгээр аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хуулийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу явуулав.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хими, химийн технологийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 20-наас 2017 оны 2 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөн “Бэст фортуна Аудит” ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хими, химийн технологийн хүрээлэн нь 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 01 дүгээр сарын 27-нд “Бэст фортуна Аудит” ХХК-нд ирүүлсэн байна.

“Бэст фортуна Аудит” ХХК нь жилийн эцсийн аудитыг 1 дүгээр сарын 27-наас 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 22-нд Хими, химийн технологийн хүрээлэнгийн удирдлагад танилцуулна.

2. Байгууллагын хууль эрх зүйн орчин:

Хими, химийн технологийн хүрээлэнгийн удирдлага нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиудын хүрээнд

үйл ажиллагаа явуулж байна. Тайлангийн хугацаанд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн **Эрхэм зорилго нь:**

- Улс орны өмнө тавигдаж буй химийн томоохон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- Монгол Улсад химийн аж үйлдвэрийг хөгжүүлэх үндэслэл боловсруулах
- Олон улсын түвшинг хангасан бүтээл туурвих
- Шинэ бүтээгдэхүүн бий болгох, мэдлэг, мэдээллийн санг өргөжүүлэх явдал юм.

Эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд туршилтаар баталж болохуйц шинэ мэдлэгийг бий болгож дэлхийн шинжлэх ухаанд хувь нэмэр оруулах, эх орны амьтан ургамал, эрдсийн гаралтай түүхий эдийн хими, физик-хими, биохими, технологийн шинж чанарыг судлан тодорхойлох, тэдгээрийг хувирган өөрчлөх байгаль орчинд ээлтэй хими, биохимийн дэвшилтэт технологи бий болгох, улмаар өгөгдсөн шинж чанартай шинэ бодис, бэлдмэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэх шинжлэх ухааны үндэслэл боловсруулах зорилготой.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

1. Хүний нөөцийн чадамжийг байнга дээшлүүлнэ. Дэлхийн болон манай улсын хэмжээний тэргүүлэгч эрдэмтдийн тоог нэмэгдүүлэх, тогтвор, суурьшилтай ажиллах бололцоогоор хангах, залуу судлаачдыг мэдлэг, боловсролоо дээшлүүлэхэд анхааран ажиллах.
2. Судалгаа, шинжилгээний үр дүнд бий болсон шинэ технологиудыг үйлдвэрлэлийн хэмжээнд турших, нэвтрүүлэх, тэдгээрийг дотоод, гадаадын зах зээлд өрсөлдөх чадвартай болгон бойжуулах, улмаар гарааны компани байгуулахад нь менежментийн дэмжлэг үзүүлэх.
3. Шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчдад шинжлэх ухаан, технологийн асуудлаар зөвлөмж хүргэх, мэдээллээр хангахын зэрэгцээ шинжлэх ухааны мэдлэг, ололт амжилтыг олон түмэнд тайлбарлан таниулах ажлыг шинжлэх ухаанчаар зохион байгуулах.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагийн дарга тус агентлагийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Төсвийн захирагчийн үүрэг гүйцэтгэж байна. Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2016 оны төсвийг Шинжлэх ухаан

технологийн сангаас олгож байна. Төсвийн захирагчтай шууд холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашигласан болно.

Аудитаар Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн шууд захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулав. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, материаллаг дүнтэй зарим гүйлгээнүүдийг түүвэрчилсэн байдлаар аудитын 11 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газраас нэгдсэн журмаар батлан мөрдүүлж байна.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах, программд нэвтрэх зэрэг аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэсэн болно. /ТАБ-СТА-В-2/

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, боловсруулах үйл ажиллагааг "Acolous" санхүүгийн программыг ашиглан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэн гаргасан байна.

5. Материаллаг байдал

Гүйцэтгэлийн шатанд 2016 оны нийт зардлын гүйцэтгэлийг суурь болгон сонгож 0.5 хувиар 10,128.38 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоов. Материаллаг байдлын хувийг 0.5 хувиар авсан шалтгаан нь гүйлгээний тоо олон, бага дүнтэй байдлыг харгалзан үзэв.

6. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь

материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Хими, химийн технологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдлийн 5 эрсдэл үр нөлөөтэй, 19 эрсдэл үр нөлөөгүй гэж тооцсон. /ТАБ-СТА-А-4-өөс үзнэ үү/

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Шинжлэх ухаан технологийн төрийн сан тус байгууллагын банкин дахь харилцах дансаар олгож, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэл, төсвийн зардлын төрөл зүйлээр хуваарилан зарцуулалтанд хяналт тавьж ажилласан байна.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны төсөв 2016 онд 1,789,352.9 мянган төгрөгөөр батлагдсанаас төсвөөс 1,789,352.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 164,580.9 мянган төгрөг тус тус авч төсвийг хэтрүүлээгүй байна.

Авлага 26,760.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь нэмэлт санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдлийг буцаан татан төвлөрүүлж 2017 онд эргүүлэн олгохоор тооцоо нийлсэн байна.

Тайланд тусгасан Эрдэс боловсруулалт, технологийн хүрээлэнгээс нэгдэх үед балансаас балансад шилжиж ирсэн 16,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий Краз авто машинаас бусад бараа материал, үндсэн хөрөнгө нь бодитойгоор оршин байгаа ба байгууллагын өмчлөлд байгаа бүхий л өмч хөрөнгийг бүрэн хамруулж, орлого, зарлага болон шилжилт хөдөлгөөн, бусад зарлагын гүйлгээнүүд нь кассад бэлнээр орсон өөрийн орлого, энэхүү орлогоос санхүүжүүлсэн лабораторийн ажилтнуудад олгосон ажлын хөлснөөс бусад данс, дүн, хугацаа, ангиллын хувьд үнэн зөв бүртгэгдсэн байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны цахим хуудас болох www.shilendans.gov.mn хуудсанд 2016 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл оруулсан байна.

Байгууллагын цахим хуудсанд байгууллагын мэдээлэлүүд, 2016 оны төсвийн гүйцэтгэлийг оруулсан байна.

9. Олж тогтоосон гол эрсдлүүд

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 25 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 горим, сорил гүйцэтгэж доорхи эрсдлүүдийг олж тогтоов. /ТАБ-СТА-В-3-аас үзнэ үү/ Үүнд:

1. Өөрийн үйл ажиллагааны орлогын бүртгэл
2. Бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээ
3. Нэмэгдэл цалин

4. Үндсэн хөрөнгө
5. Томилолтын зардал

10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Гол, онцлог гүйлгээ байхгүй

11. Аудитаар илэрсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтуудад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг хэмжээтэй алдаа зөрчилүүд нь санхүүгийн тайлангийн **оршин байх, эрх үүрэг, тохиолдсон байх, үнэн зөв** гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байсан ба холбогдох хуулийн заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

1. Бэлнээр кассанд авч байгаа өөрийн үйл ажиллагааны орлого (шинжилгээний орлого, түрээсийн орлого), кассын дансны үлдэгдэл, зарлагын гүйлгээг санхүүгийн тайланд бүрэн тусгаагүй, зөвхөн орлого зарлагын зөрүүгээр банкин дахь харилцах дансанд тушааж тайлагнасан нь **Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан зааврын “Үйлчилгээний орлогыг холбогдох хууль тогтоомж, заавар гэрээнд заасан төлбөр ногдуулах журмын дагуу төлбөрийн хувь хэмжээ, төлөх хугацаа болон төлбөр хийсэн баримтыг үндэслэн бүртгэнэ. Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлогыг дараах байдлаар бүртгэнэ:**

(а) **Ажил үйлчилгээний орлогын авлагыг:**

Дт. Авлага Кт.Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого

(б) **Энэхүү орлогыг авахад;**

Дт. Мөнгөн хөрөнгө Кт. Авлага”-д бүртгэх гэсэн заалттай нийцэхгүй байна

2. Лабораторийн шинжилгээ хийсэн ажилтнуудын ажлын хөлсөнд 5,684.0 мянган төгрөгийг олгохдоо **Хими, химийн технологийн хүрээлэнгийн дотоод журмын “орлогоос зардлыг хассан дүнгээс 45 хувийг олгоно”** гэсэн заалтай нийцэхгүй байна

- ✓ **Шийдвэрлэсэн нь:** - Кассанд бэлнээр авч байгаа шинжилгээний орлого, түрээсийн орлого, кассын зарлагын гүйлгээг санхүүгийн тайланд бүрэн тусгаж тайлагнах зөвлөмж өгөв
-Бэлэн мөнгөний хяналтыг сайжруулах, лабораторийн бүртгэлийн журналыг боловсронгуй болгох зөвлөмж өгөв

3. Бодогдсон цалин, захирлын тушаалыг тулган шалгахад ажилтнуудын нэмэгдэл цалинг илүү, дутуу олгосон байх ба нийт дүнгээр 2,036.5 мянган төгрөгөөр дутуу бодогдсон нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 хэсэг дэх “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар,**

энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна

- ✓ **Шийдвэрлэсэн нь:** Холбогдох хууль, заавар, шийдвэр, Эрдмийн цолны үнэмлэх, зэрэг дэв, ур чадварын нэмэгдлийг баримтанд үндэслэн тушаал гаргаж нэмэгдэл цалинг үнэн зөв тооцоолж байх зөвлөмж өгөв

4. Эрдэс боловсруулалт, технологийн хүрээлэн Хими, химийн технологийн хүрээлэнтэй нэгдэхэд балансаас балансад шилжиж ирсэн 16,000.0 мянган төгрөгийн үнэтэй Краз авто машин үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа боловч биетээр байхгүй байхад бэлнээр тоолсон, бусад хөрөнгийн тооллогын актыг үндэслэн тооцоо бодсон акт үйлдээгүй нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 хэсэг дэх “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”** гэсэн заалттай нийцэхгүй байна

- ✓ **Шийдвэрлэсэн нь:**
 1. Шүүхийн шийдвэрийг үндэслэн хөрөнгийн асуудлыг эцэслэн шийдвэрлэх зөвлөмж өгөв
 2. Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогын үр дүн, аудитын зөвлөмжийг үндэслэн аудитын явцад тооцоог нөхөн бодсон болно

5. Томилолтын урьдчилгаа 7.949,0 мянган төгрөгийг авлагын дансаар дамжуулж (дараа тайлан гаргагчийн тооцоо) бүртгээгүй, баримтын бүрдэл дутуу **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “13 дугаар зүйлийн 13.1 Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”** гэсэн заалттай нийцэхгүй байна

- ✓ **Шийдвэрлэсэн нь:** Томилолтын тооцоог авлага (дараа тайлан гаргагч)-ын дансанд бүртгэж томилолтын тайлан, хүчин төгөлдөр, иж бүрдэлтэй баримтыг үндэслэн авлагын тооцоог хаах дансны бичилт хийж байх зөвлөмж өгөв

Аудитаар илэрсэн асуудлыг Хими, химийн технологийн хүрээлэнгийн удирдлага авч үзэж, өгсөн зөвлөмжийг хойшид ажилдаа мөрдөж ажиллахаар болсон тул материаллаг алдаагүй гэж үзлээ.

5. **Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар**
Залруулагдаагүй алдаа байхгүй гэж үзэв.

13.Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад асуудал байгаагүй болно.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Томилолтын тайлангийн баримтын бүрдэл, Краз авто машины талаар дараагийн аудитаар дахин авч үзнэ.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар 31,669.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн ба үүнээс 16,000.0 мянган төгрөгийн хөрөнгийн зөрчил нь тус байгууллагын үйл ажиллагаанаас хамаараагүй тул материаллаг бус гэж үзэв

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнө жилүүдэд Үндэсний аудитын газраас аудит хийж байгаагүй тул өгөгдсөн зөвлөмж байхгүй ба 2016 онд тус байгууллага өөрөө аудит хийлгэх хүсэлт гаргасан, аудит хийх хуваарь 2017 оны 1 дүгээр сард гарсан тул завсрын аудит хийгдээгүй болно.

17. Зөрчилгүй санал дүгнэлт

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон илчлэл тодруулгуудад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахи хаягаар харилцана уу:

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46 Бага тойруу 6

Web: www.mnao.gov.mn

Санхүүгийн аудитын газрын дарга
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 260512
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитор Н.Нямдаваа
Утас: 260512
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
“Бэст фортуна Аудит” ХХК
Утас: 324338
И-мэйл: fortune_audit@yahoo.com

Захирал: Ж.Оюунцэцэг
Утас: 89116465, 98056465
И-мэйл: Oyuntsetseg_cpa@yahoo.com

Аудитын багийн ахлагч:
Аудитор: Н.Одончимэг
Утас: 98006465
И-мэйл: nodnoo@yahoo.com

Тэргүүлэх ач холбогдол №1

Асуудал 1: Касс,
өөрийн нүйлажиллагааны орлого,
зардал

Тэргүүлэх ач холбогдол №2

Асуудал 1: Нэмэгдэл цалин

Асуудал 2: Үндсэн хөрөнгө

Асуудал 3: Томилолтын зардал

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Хими, химийн технологийн хүрээлэнгийн удирдлагад зориулан бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим сорил нь санхүүгийн тайлан, илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Энэхүү зөвлөмж танай байгууллагын бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад хамтран ажилласан удирдлага болон бусад ажилтануудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Касс, өөрийн үйл ажиллагааны орлого, зардал

Тэргүүлэх ач холбогдол № 1

Аудитын ажиглалт

1. Бэлнээр кассанд авч байгаа өөрийн үйл ажиллагааны орлого (шинжилгээний орлого, түрээсийн орлого), кассын дансны үлдэгдэл, зарлагын гүйлгээг санхүүгийн тайланд бүрэн тусгаагүй, зөвхөн орлого зарлагын зөрүүгээр банкин дахь харилцах дансанд тушааж тайлагнасан нь **Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан зааврын “Үйлчилгээний орлогыг холбогдох хууль тогтоомж, заавар гэрээнд заасан төлбөр ногдуулах журмын дагуу төлбөрийн хувь хэмжээ, төлөх хугацаа болон төлбөр хийсэн баримтыг үндэслэн бүртгэнэ.Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлогыг дараах байдлаар бүртгэнэ:(а) Ажил үйлчилгээний орлогын авлагыг:**

Дт. АвлагаКт.Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого

(б)Энэхүү орлогыг авахад;

Дт. Мөнгөн хөрөнгө Кт. Авлага”-д бүртгэх гэсэн заалттай гэсэн заалттай нийцэхгүй байна

1. Лабораторийн шинжилгээ хийсэн ажилтнуудын ажлын хөлсөнд 5,684.0 мянган төгрөгийг олгохдоо **Хими, химийн технологийн хүрээлэнгийн дотоод журмын “орлогоос зардлыг хассан дүнгээс 45 хувийг олгоно”** гэсэн заалтай нийцэхгүй байна

Эрсдэл

1. Санхүүгийн тайлан дахь орлого, зардал буруу илэрхийлэгдэх, бэлэн мөнгө зориулалтын бусаар ашиглагдах

(Оршин байх, Тохиолдсон байх,
Үнэн зөв байх)

Аудитын зөвлөмж

1. Кассанд бэлнээр авч байгаа шинжилгээний орлого, түрээсийн орлого, кассын зарлагын гүйлгээг санхүүгийн тайланд бүрэн тусгаж тайлагнах

2. Бэлэн мөнгөний хяналтыг сайжруулах, лабораторийн бүртгэлийн журналыг боловсронгуй болгох

Үйлчлүүлэгчийн хариу

Орлого, зарлагын зөрүүгээр харилцах руу орлого авч тайланд тусгаж байсан. Хойшид зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ

Асуудал 1: Нэмэгдэл цалин

Аудитын ажиглалт

Бодогдсон цалин, захирлын тушаалыг тулган шалгахад ажилтнуудын нэмэгдэл цалинг илүү, дутуу олгосон байх ба нийт дүнгээр 2,036.5 мянган төгрөгөөр дутуу бодогдсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 хэсэг дэх “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна

Эрсдэл

Цалин хөлс илүү, дутуу олгогдох, төсвийн зардал улмаар санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх

(Тохиолдсон байх, Үнэн зөв байх)

Тэргүүлэх ач холбогдол № 2

Аудитын зөвлөмж

Холбогдох хууль, заавар, шийдвэр, Эрдмийн цолны үнэмлэх, зэрэг дэв, ур чадварын нэмэгдлийг баримтанд үндэслэн тушаал гаргаж нэмэгдэл цалинг үнэн зөв тооцоолж байх

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж хойшид анхаарч ажиллана

Асуудал 2: Үндсэн хөрөнгө

Тэргүүлэх ач холбогдол № 2

Аудитын ажиглалт

Эрдэс боловсруулалт, технологийн хүрээлэн Хими, химийн технологийн хүрээлэнтэй нэгдэхэд балансаас балансад шилжиж ирсэн 16,000.0 мянган төгрөгийн үнэтэй Краз автомашин үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа боловч биетээр байхгүй байхад бэлнээр тоолсон, бусад хөрөнгийн тооллогын актыг үндэслэн тооцоо бодсон акт үйлдээгүй нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 хэсэг дэх “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна**

Эрсдэл

Санхүүгийн тайланд хөрөнгийн үлдэгдэл буруу тайлагнагдах, өмч хөрөнгө үрэгдэх, дотоод хяналт сулрах

(Оршин байх, Тохиолдсон байх, Үнэн зөв)

Аудитын зөвлөмж

1. Шүүхийн шийдвэрийг үндэслэн хөрөнгийн асуудлыг эцэслэн шийдвэрлэх
2. Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогын үр дүнг үндэслэн тооцоог нөхөн бодох

Үйлчлүүлэгчийн хариу

Эрдэс боловсруулалт, технологийн хүрээлэнгийн мэдэлд байх үед уг машин алга болсон бөгөөд Шүүхээр шийдвэрлүүлэхээр хандсан асуудал шийдэгдээгүй, 2017 онд дахин хөөцөлдөнө

Асуудал 3: Томилолтын зардал

Тэргүүлэх ач холбогдол № 2

Аудитын ажиглалт

Томилолтын урьдчилгаа 7.949,0 мянган төгрөгийг авлагын дансаар дамжуулж (дараа тайлан гаргагчийн тооцоо) бүртгээгүй, баримтын бүрдэл дутуу **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “13 дугаар зүйлийн 13.1 Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”** гэсэн заалттай нийцэхгүй байна

Эрсдэл

Санхүүгийн тайланд хөрөнгийн үлдэгдэл буруу тайлагнагдах, өмч хөрөнгө үрэгдэх, дотоод хяналт сулрах
(Оршин байх, Тохиолдсон байх, Үнэн зөв)

Аудитын зөвлөмж

Томилолтын тооцоог авлага (дараа тайлан гаргагч)-ын дансанд бүртгэж томилолтын тайлан, хүчин төгөлдөр, иж бүрдэлтэй баримтыг үндэслэн авлагын тооцоог хаах дансны бичилт хийж байх

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ

ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016 он 12 сар 31 өдөр

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2015-12-31	2016-12-31
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	-
Төгрөг	-	
Төрийн сангийн харилцах	-	
АВЛАГА	47,000,028.18	26,760,944.00
Бусад авлага	47,000,028.18	26,760,944.00
Байгууллагаас авах авлага	47,000,028.18	26,760,944.00
БАРАА МАТЕРИАЛ	87,532,558.56	80,954,497.69
Түүхий эд материал	21,636,971.63	18,823,704.13
Тусгай зориулалттай материал	21,636,971.63	18,823,704.13
Хангамжийн материал	65,895,586.93	62,130,793.56
Бичиг хэргийн материал	8,744,330.37	2,218,667.00
Сэлбэг хэрэгсэл	40,634,534.20	43,693,434.20
Бусад хангамжийн материал	16,516,722.36	16,218,692.36
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	134,532,586.74	107,715,441.69
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,930,601,454.32	1,885,588,090.21
Биет хөрөнгө	1,929,741,458.53	1,884,906,427.74
Барилга, байгууламж	2,662,785,486.10	2,662,785,486.10
Хуримтлагдсан элэгдэл	(897,817,945.71)	(1,007,629,189.11)
Авто-тээврийн хэрэгсэл	31,913,000.00	31,913,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(26,306,926.73)	(28,292,426.81)
Машин, тоног төхөөрөмж	2,068,586,791.27	2,174,814,166.27
Хуримтлагдсан элэгдэл	(1,953,009,381.28)	(1,988,488,995.31)
Тавилга, аж ахуйн эд хогшил	147,406,181.42	148,759,991.42
Хуримтлагдсан элэгдэл	(119,140,174.41)	(124,142,532.73)
Номын фонд	12,817,136.16	13,042,136.16
Бусад үндсэн хөрөнгө	2,900,000.00	2,900,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(392,708.29)	(755,208.25)
Биет бус хөрөнгө	859,995.79	681,662.47
Програм хангамж	3,270,000.00	3,270,000.00
Хасагдуулга	(2,410,004.21)	(2,588,337.53)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,930,601,454.32	1,885,588,090.21
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,065,134,041.06	1,993,303,531.90
Өглөг	4,836,709.00	-
Бусад өглөг	4,836,709.00	-
Байгууллагад төлөх өглөг	4,836,709.00	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	2,065,134,041.06	1,993,303,531.90
Засгийн газрын хувь оролцоо	2,060,297,332.06	1,993,303,531.90
Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/	3,077,104,818.51	3,077,104,818.51
Өмч: -Төрийн өмч	3,077,104,818.51	3,077,104,818.51
Хуримтлагдсан үр дүн	(1,829,739,217.02)	(1,896,733,017.18)
Өмнөх үеийн үр дүн	(1,829,739,217.02)	(1,829,739,217.02)
Тайлант үеийн үр дүн		(66,993,800.16)
Дахин үнэлгээний зөрүү	812,931,730.57	812,931,730.57
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	2,065,134,041.06	1,993,303,531.90

ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2016 он 12 сар 31 өдөр

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2015-12-31	2016-12-31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	1,768,659,898.97	1,958,681,857.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,065,000.00	12,088,868.00
Нийтлэг татварын бус орлого	14,065,000.00	12,088,868.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	14,065,000.00	12,088,868.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,070,000.00	12,088,868.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,200,000.00	
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,795,000.00	
Тусламж, санхүүжилтийн орлого	1,754,594,898.97	1,946,592,989.00
Улсын төвлөрсөн төсвөөс	1,473,750,918.97	1,789,352,900.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,473,750,918.97	1,789,352,900.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	168,297,380.00	134,720,850.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	168,297,380.00	23,945,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны		110,775,850.00
Төсвийн захирагчаас	112,546,600.00	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	112,546,600.00	-
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс		22,519,239.00
Нийгмийн даатгалын сангийн санхүүжих		22,519,239.00
Үйл ажиллагааны зардлын дүн	2,293,497,878.48	2,025,675,657.16
УРСГАЛ ЗАРДАЛ	2,286,317,054.73	2,001,976,418.16
Бараа , ажил үйлчилгээний зардал	2,286,317,054.73	2,001,976,418.16
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,157,871,607.40	1,235,685,372.75
Цалин	1,066,230,318.40	1,190,646,972.75
Нэмэгдэл цалин	77,754,529.00	-
унаа, хоолны хөнгөлөлт	13,886,760.00	45,038,400.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,222,498.54	133,102,267.68
Тэтгэвэрийн даатгалын шимтгэл	93,509,508.13	133,102,267.68
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	37,712,990.41	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,565,690.00	98,363,118.97
Гэрэл цахилгааны зардал	35,352,351.00	38,881,624.00
Түлш халаалтын зардал	37,777,847.24	47,609,897.97
Цэвэр бохир усны зардал	13,435,491.76	11,871,597.00
Хангамж, бараа материалын зардал	2,943,687.03	6,123,005.23
Бичиг хэргийн материал	303,500.00	105,000.00
Тээвэр, шатахууны зардал	-	1,545,792.00
Шуудан холбоо, интернэтийн зардал	2,317,287.03	2,854,283.23
Ном, хэвлэлийн зардал	322,900.00	1,056,500.00
Бага үнэтэй түрэн элэгдэх зүйлс	-	561,430.00
Нормативт зардал	-	1,582,340.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,582,340.00
Эд хогшил, урсгал засварын зардал	55,425,000.00	21,557,500.00
Урсгал зардал	55,425,000.00	21,557,500.00
Томилолт, зочны зардал	17,120,000.00	35,653,500.00
Дотоод томилолтын зардал	17,120,000.00	35,653,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төрөл	9,412,900.00	206,349,171.05
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	8,247,800.00	204,513,471.05
Аудит, баталгаажуулалт зэрэг тогтоох зардал		900,000.00
Тээврийн хэрэгслийн зардал	70,100.00	70,100.00
Мэпээллийн технологийн үйлчилгээний	550,000.00	-
Газрын төлбөр	545,000.00	865,600.00
Бараа үйлчилгээний бусад зардал	825,755,671.76	263,560,142.48

Бараа үйлчилгээний бусад зардал	140,818,950.00	99,796,793.37
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын		10,943,800.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	684,936,721.76	152,819,549.11
Урсгал шилжүүлэг	7,180,823.75	23,699,239.00
Засгийн газрын ургал шилжүүлэг	5,320,823.72	(66,993,800.16)
Засгийн газрындотоод шилжүүлэг	5,320,823.72	-
Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	22,519,239.00
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		22,519,239.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	-
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	360,000.03	1,180,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	360,000.03	1,180,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(524,837,979.51)	(66,993,800.16)
НИЙТ ҮР ДҮН	(524,837,979.51)	(66,993,800.16)

Хими, химийн технологийн хүрээлэн

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 он 12 сар 31 өдөр

/төгрөгөөр/

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	1,666,605,930.00	804,752,677.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,270,000.00	12,474,641.18
Нийтлэг татварын бус орлого	12,270,000.00	12,474,641.18
Төсөвт байгууллагын өөрийн орлого	12,270,000.00	12,474,641.18
Үндсэн үйл ажиллагааны орлого	10,070,000.00	12,088,868.00
Туслах үйл ажиллагааны орлого	2,200,000.00	385,773.18
ТУМЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	49,500.00	1,789,352,900.00
Улсын төвлөрсөн төсвөөс	13,373,491,950.00	1,789,352,900.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,373,491,950.00	1,789,352,900.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	168,297,380.00	164,580,930.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	168,297,380.00	23,945,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны		140,635,930.00
Төсвийн захирагчаас	112,546,600.00	
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	112,546,600.00	
Нийгмийн даатгалын сангаас төсвөөс санхүүжих		22,519,239.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		22,519,239.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,554,401,120.00	1,898,100,700.18
УРСГАЛ ЗАРДАЛ	1,517,360,216.25	1,847,640,517.18
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,517,360,216.25	1,847,640,517.18
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,076,446,067.40	1,235,685,372.75
Үндсэн цалин	1,035,037,667.40	1,190,646,972.75
Унаа хоолны хөнгөлөлт	41,408,400.00	45,038,400.00
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	116,932,853.79	133,102,267.68
Тэтгэврийн даатгалын шимтгэл	116,884,895.04	133,102,267.68
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	47,958.75	
Байх ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,401,344.00	103,199,827.97
Гэрэл цахилгааны зардал	32,571,430.00	39,881,624.00
Түлш, халаалтын зардал	31,694,422.24	50,133,001.97
Цэвэр, бохир усны зардал	13,135,491.76	13,185,202.00
Хангамж, бараа материалын зардал	8,821,183.06	6,890,985.23
Бичиг хэргийн материал	723,900.00	253,000.00
Тээвэр, шатахууны зардал	1,332,000.00	1,545,792.00
Шуудан холбооны зардал	2,088,135.06	2,854,283.23
Ном, хэвлэлийн зардал	322,900.00	1,281,500.00
Бага үнтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,354,248.00	956,410.00
Норматив зардал	2,772,466.00	2,100,000.00
Норматив хувцас, зөөлөн эдлэл	2,772,466.00	2,100,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	56,658,000.00	21,557,500.00
Урсгал засвар	56,658,000.00	21,557,500.00
Томилолт, зочны зардал	17,120,000.00	35,653,500.00
Дотоод албан томилолт	17,120,000.00	35,653,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	13,699,112.00	241,432,890.55
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	12,534,012.00	239,597,190.55
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		900,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	70,100.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ	550,000.00	
Газрын төлбөр	545,000.00	865,600.00
Бараа үйлчилгээний бусад зардал	147,509,190.00	68,018,173.00
Бараа үйлчилгээний бусад зардал	147,509,190.00	57,074,373.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		10,943,800.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,040,903.75	50,460,183.00

Засгийн газарын урсгал шилжүүлэг	5,320,823.72	
Засгийн газарын урсгал шилжүүлэг	5,320,823.72	
Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	22,519,239.00
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж		22,519,239.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,500,000.00	
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,220,080.03	27,940,944.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	30,220,080.03	27,940,944.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	112,204,810.00	90,827,010.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЛГЭЭ		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛЫН ГҮЙЛГЭЭ	112,204,810.00	90,827,010.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	112,204,810.00	90,827,010.00
Дотоод эх үүсвэр	112,204,810.00	90,827,010.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	112,204,810.00	90,827,010.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(112,204,810.00)	(90,827,010.00)
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ДҮН		
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016 он 12 сар 31 өдөр

/ төгрөгөөр /

Д/Д	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2015 оны 01-р сарын 01-ээр үлдэгдэл	-			-	
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-		-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-		-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-		-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-			-	-
8	2015 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	3,077,104,818.51	812,931,730.57	(1,829,739,217.02)	-	2,060,297,332.06
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-	-	-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,077,104,818.51	812,931,730.57	(1,829,739,217.02)	-	2,060,297,332.06
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-		-	-	-
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-		-	-	-
13	Орлогын тайланд хилээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-	-	-
14	Тайлант үеийн үр дүн	-		(66,993,800.16)	-	(66,993,800.16)
15	2016 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	3,077,104,818.51	812,931,730.57	(1,896,733,017.18)	-	1,993,303,531.90

ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2016 он 12 сар 31 өдөр

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Сарын гүйцэтгэл	Хувь
Мөнгөн хөрөнгийн оны эхнийн үлдэгдэл			-	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		137,819,986.00	(137,819,986.00)	
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		137,819,986.00	(137,819,986.00)	
Бараа ажил үйлчилгээний зардал		137,819,986.00	(137,819,986.00)	
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		51,216,512.00	(51,216,512.00)	
Үндсэн цалин		51,216,512.00	(51,216,512.00)	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		5,729,205.00	(5,729,205.00)	
Тэтгэвэрийн даатгалын		5,729,205.00	(5,729,205.00)	
Эд хогшил худалдан авах		945,000.00	(945,000.00)	
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		945,000.00	(945,000.00)	
Томилолт, зочны зардал		1,911,800.00	(1,911,800.00)	
Дотоод албан томилолт		1,911,800.00	(1,911,800.00)	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		9,999,296.00	(9,999,296.00)	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамж		9,999,296.00	(9,999,296.00)	
Бараа ажил үйлчилгээний бусад зардал		68,018,173.00	(68,018,173.00)	
Бараа үйлчилгээний бусад зардал		57,074,373.00	(57,074,373.00)	
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		10,943,800.00	(10,943,800.00)	
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		164,580,930.00	(164,580,930.00)	
Нэмэлт санхүжилтийн орлого		164,580,930.00	(164,580,930.00)	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт		23,945,000.00	(23,945,000.00)	
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн		140,635,930.00	(140,635,930.00)	
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-	
Төсвийн бусад мэдээллийн ангилал			-	
Байгууллагын тоо			-	
Ажиллагсадын тоо	127.00	127.00	-	100%
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100%
Суралцагчдын тоо /жилийн дунджаар/			-	
Гүйцэтгэх ажилтан	99.00	99.00	-	100%
Үйлчлэх ажилтан	27.00	27.00	-	100%